

МЭРГЭЖЛИЙН УРТЫН ДУУЧИН БЭЛТГЭСЭН СУРГАЛТЫН ҮЕ ШАТНЫ АСУУДАЛД

Цэрэнгийн Туяацэцэг¹
Цэрэнгийн Чулуунцэцэг^{2,*}

¹ Соёл урлагийн их сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), дэд профессор, Соёл урлагийн их сургууль, Улаанбаатар, Монгол улс

* Холбоо барих зохиогч: chuka0588@gmail.com

Хураангуй: Монгол улс дэлхийн хөгжилтэй хөл нийлэн алхах болж, уртын дууны уламжлал 1950-аад оноос хойш нэлээд бүдгэрч, ялангуяа 1970-аад он гэхэд бараг мартагдах шахаж байх үед уртын дуучин Ж.Дорждагва, түүний шавь Н.Норовбанзад нар уртын дуугаа сургалтаар дамжуулан залгамжилж, хойч үедээ уламжлуулах ажлыг санаачлан эхлүүлсэн юм. Тиймээс мэргэжлийн уртын дуучин бэлтгэсэн сургалтын үе шатыг тоймлон судлах зорилготой.

Түлхүүр үг: багш, алдарт дуучин, танхимын сургалт, судлаач, шавь сургалт

TRAINING STAGES FOR THE PREPARATION OF LONG SONG PROFESSIONAL SINGERS

Tuyatsetseg Tseren¹
Chuluuntsetseg Tseren^{2,*}


¹ Doctoral student of Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Associate Professor, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: chuka0588@gmail.com

Abstract: When Mongolia developed according to the world progress the tradition of the long song became considerable unclear from the 1950s and in particular was almost forgotten in the 1970s. Then famous long song singer J.Dorjdagva and his student N.Norovbanzad started the professional training to pass on the tradition of the long song to the future generation at their initiative. Yes. The aim is to study the training stages of the preparation of professional long song singers.

Key words: *teacher, famous singer, class training, researcher, student training*



Аргазүй

Судалгааг мэргэжлийн уртын дуучин бэлтгэн гаргасан түүхэн үечлэл болон мэргэжлийн уртын дуучдын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох зорилттойгоор бичиглэл судалгааны аргаар гүйцэтгэв. Судалгааны хэрэглэгдэхүүнд Монгол улсын Боловсролын их сургууль, Соёл урлагийн их сургууль, Монгол улсын консерватор, Сити их сургууль зэрэг урлагийн мэргэжлийн сургуулийн 1969-2023 оны материал, сургалт судалгааны ном, баримт бичиг, асуумжаар мэдээлэл цуглуулах арга, сурвалжлагын арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших аргуудыг ашигласан болно.

Үндсэн хэсэг

Монголчууд нь уртын дууг эртнээс гэр сургалтаар болон өөрийн идэвх санаачилгаар сурч, дуулан ирсэн түүхтэй. Харин Монгол улсад 1930-аад онд анхны театр буюу Пөмбөгөр (Бөмбөгөр) ногоон хэмээн ард түмний дунд нэршсэн Ардын цэнгэлдэх хүрээлэн баригдаж, албан ёсоор уртын дууг анх тайзан дээр дуулах түүх эхэлсэн.

Монголын алдарт дуучин, судлаач, сурган хүмүүжүүлэгч М.Дугаржавын 1934 онд бичсэн “Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах тухай”, “Дуулах, хөгжимдөх тухай өчүүхэн сануулга” хэмээх хоёр өгүүлэл уртын дууг дуулах ур зүйн болоод заан сургах, уламжлан хөгжүүлэх сэдэвт бүтээлүүдийн анхдагч нь болно. Монгол улс ЮНЕСКО-ийн 2005 оны “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” конвенцод 2007 онд нэгдэн орсон байдаг. Сүүлийн жилүүдэд Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын асуудал эрчимтэй хөгжиж, үүнийг өөрийн салбарын үйл ажиллагаандаа хэрэглэж, ашиглаж байгаа байгууллага нь эдийн засгийн хувьд өсөлтийг бий болгоод байна. Үүнд салбар дундын хамтын ажиллагаа хамгийн чухал юм.

Соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах тухай конвенц нь “Соёлын биет бус өв нь соёлын олон төрөл байдлын эх булаг, тогтвортой хөгжлийн баталгаа болж байдаг учир чухал ач холбогдолтой” гэж хүлээн зөвшөөрөх болжээ (Эрхэмтөгс, 2019, 11). Монгол ардын урлагийн сонгодог хэлбэр, манай ард түмний хэдэн зууны турш цогцлон бүтээсэн оюуны гайхамшигт бүтээл бол уртын дуу билээ (Норовбанзад, 2000, 3).

Эрдэмтэн Гэрэлтү 2003 онд “Монгол уртын дуу, жич дуулахуй” хэмээх бүтээлээ хэвлүүлжээ. Тэрээр уг бүтээлийнхээ “Уртын дууны сургалт болон дасгал” дөрөвдүгээр бүлэгт 1. Уламжлалт сургалт (удам угсааны сургалт, багш шавийн сургалт нийгэм нийтийн сургалт) 2. Мэргэжлийн сургалт (анхан шат, боловсруулалт дүрэмжүүлэлц) 3. Дасгал боловсрол (амьсгалын дасгал, дуугаргах аргын дасгал, уран чимэглэлийн дасгал) 4. Хоолойн царааг өргөтгөх дасгал 5. Дасгал хийх шатлал хэмээн нэлээд нарийвчлан өгүүлсэн байна (Гэрэлтү, 2003, 219, 264).

Б.Батмэнд “Монгол ардын уртын дууны урлагт Н.Норовбанзадын хийсэн шинэчлэл” өгүүлэлдээ алдарт дуучин Намжилын Норовбанзадын дуулах ур зүйн онцлогийг өгүүлэхээс гадна 1974 онд уртын дуучдын түр сургууль байгуулж ажиллуулснаар анх Монгол улсад уртын дууны танхимын сургалтыг эхлүүлсэн тухай,

“Талын морьтны дуу” хэмээх гарын авлага бичиж гаргасан тухай өгүүлсэн байна.

Судлаач М.Дорждагва “Хамжлагат ёс халагдаад 100 шахам жил өнгөрсөн ч хуучин Засагт хан аймгийн халхчуудын уртын дууны жинтэйнхэн хэсгийг Чингисийн алтан ургийн үртэс нарын төрт ёсны зан үйлийн дууны өв эзэлсээр байгаа” (Дорждагва, 2018, 55) гэжээ. Дээрх баримтаас үзвэл, монголын ард түмэн эрдэмтэн судлаач, дуучин хөгжимчин, багш, жирийн малчин ард ялгалгүй уртын дуугаа сэтгэл зүрхнээсээ хайрладаг, манай үндэстний үнэт өв, дэлхийд байхгүй өвөрмөц урлаг мөн гэдгийг ухаарч ойлгодог, уламжлал таслалгүй авч явахыг хэнээр ч хэлүүлэлгүйгээр хичээн чармайдаг нь илхэн харагдана хэмээжээ.

Уртын дууны мэргэжлийн сургалтыг үечлэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 1969 оны 6 сарын сургалт
- 1974 оны 3 сарын сургалт
- 1977-1984 оны Улсын багшийн дээд сургуулийн дэргэдэх сургалт
- 1990 оноос өнөөг хүртэлх үеийн их сургуулиудын сургалт (СУИС, МУК, Сити) гэж ангилан үзлээ.

Монгол улс дэлхийн хөгжилтэй хөл нийлэн алхах болж уртын дууны уламжлал 1950-аад оноос хойш нэлээд бүдгэрч, ялангуяа 1970-аад он гэхэд бараг мартагдах шахаж байх үед уртын дуучин Ж.Дорждагва, түүний шавь Н.Норовбанзад нар уртын дуугаа залгамжилж, хойч үедээ уламжлуулах ажлыг санаачлан эхлүүлжээ.

Алдарт гавьяат дуучин Ж.Дорждагва 1968 онд уртын дуучдын улсын уралдааныг зохион байгуулж, ерөнхий шүүгчээр ажиллажээ. Түүний дараа жил буюу 1969 онд Ж.Дорждагва өөрийн санаачилгаар Улсын Ардын Дуу Бүжгийн Чуулгын дэргэд зургаан сарын курс нээж, орон нутгийн театр, чуулгад ажиллах уртын дуучдыг бэлтгэжээ” (Бадраа, 1998, 15). Энэ тухайд ахмад уран бүтээлч СТА М.Төмөрбат ярилцлагадаа “...1969 оны 4 дүгээр сарын 1-ээс 10 сарын 1 хүртэлх хугацаанд зургаан сарын курс зохион байгуулсан юм. Энэ курс нь уртын, богинын гэсэн хоёр ангитай. Уртын дууны ангид арваад дуучид суралцаж байсан. Үүнд: Баянхонгорын Ч.Намжил, Р.Дулмаа, Өвөрхангайгаас МУГЖ Д.Баттөмөр, Завханаас Цагаандай, Отгондаваа, Дундговь би, Өмнөговь аймгаас Долгорсүрэн гэх мэт улсууд оролцон суралцаж байлаа” (Төмөрбат, 2024) хэмээн өгүүлсэн. Түүний уртын дуучин болох ажил, амьдралын зам нь энэ цаг үеийн сургалтаас эхэлжээ.

Түүний дараа жил буюу 1970 онд Ж.Дорждагвын шавь, алдарт дуучин Н.Норовбанзад Хөгжим бүжгийн дунд сургуулийн сурагч Д.Цэвээнсүрэнг өөрийн болон сургуулийн захиргааны хүсэлтээр шавь болгон авч, мэргэжлийн уртын дуучин болгон төгсгөсөн байна. 1974 онд Уртын дууны гурван сарын сургалт явагджээ. Энэ тухайд Ардын жүжигчин А.Нэргүйгээс ярилцлага авч тодруулахад, тэрбээр “...1974 онд гурван сарын курс зохион байгуулагдсан. Энэ курсын ахлагчаар Н.Норовбанзад, дуулах ур зүйн багшаар алдарт уртын дууч Ж.Дорждагва, Б.Лхамжав, С.Сүлэгмаа, С.Цоодол, концертмейстр багшаар И.Цогбадрах, хөгжмийн онолын багш Т.Насанбуян, төгөлдөр хуурын багш М.Булган нар багшилж байлаа. Хэнтий аймгаас Ц.Нансалмаа, Говь-Алтай аймгаас З.Тэрбиш, Төв аймгаас Цагаан-Өвгөн, Завхан аймгаас Ж.Гэрэлтогтох, Ховд аймгаас Ж.Нямсүрэн, Увс аймгаас Жаргал, Хөвсгөл аймгаас Жаргал, Архангай

аймгаас Б.Сумаа, Дорнод аймгаас Алтангэрэл, Өмнөговь аймгаас Долгор, Баян-Өлгий Назырова, Улаанбаатар хотоос Пүрэв гэх зэрэг хүмүүс суралцаж төгссөн юм. Эдгээр хүмүүс бүгд орон нутгийн театр чуулгадаа ажиллаж, улсын алдар цолыг хүртсэн дээ” (Нэргүй, 2024) гэжээ.

Ийнхүү 1969 оноос Монгол улсад уртын дууны танхимын сургалт албан ёсоор эхэлсэн түүхэн үйл явдал болсон боловч үе үе тасалдаж, хараахан тогтворжиж чадахгүй байсаар байжээ. Дөрвөн жил дахин ийм сургалт зохион байгуулагдахгүй, мэргэжлийн уртын дуучин төгсөхгүй байсаар 1974 онд Соёлын яаманд хүсэлт гаргаж, уртын дуучдын гурван сарын түр сургуулийг албан ёсоор байгуулж, захирлаар нь Н.Норовбанзад томилогдож, Ж.Дорждагва, Б.Лхамжав, С.Цоодол, С.Сүлэгмаа зэрэг нэртэй сайн дуучид багшилжээ. 1977 онд Улсын Багшийн дээд сургуулийн дуулаачийн ангид уртын дууны мэргэжлээр анхны элсэлт авч, 1982 онд анхны төгсөлтөөр Ц.Дэлгэр, Д.Хандсүрэн, 1984 онд Т.Алтантулга нар төгсөж дээд боловсролтой анхны уртын дуучид болжээ. Ийнхүү 1986 онд УБДС-д Ц.Чулуунцэцэг, Ц.Ичинхорол, 1987 онд Ц.Дашцэрмаа нар элсэн орж, 1990 оноос УБДС-ийн дуулаачийн анги Соёл урлагийн их сургууль болон өргөжсөн бөгөөд 1991 онд Ц.Чулуунцэцэг, 1992 онд Ц.Дашцэрмаа, 1993 онд Ц.Ичинхорлоо нар суралцан төгсжээ. Харин 1991-1996 онд С.Цогтсайхан, Б.Батболд, Ц.Отгонцэцэг, Н.Далхжав, С.Байгалмаа нарын уртын дуучид суралцан төгсжээ. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль нь Монгол улсад уртын дуучин бэлтгэх өдрийн болон эчнээ сургалтыг явуулдаг гол төв сургууль болж, нийт 240 гаран мэргэжлийн уртын дуучин бэлтгэсэн байна. СУИС 1991-1998 он хүртэл таван жилийн сургалттай байсан ба 1994 онд элсэн орсон оюутнууд нь зургаан жилийн сургалтаар төгссөн. 2000-2016 он хүртэл таван жилийн сургалтаар, 2016 оноос одоог хүртэл дөрвөн жилийн сургалтаар мэргэжлийн уртын дуучин бэлтгэн гаргаж байна (СУИС-ийн архив, 2022).

Хөгжим бүжгийн коллеж мэргэжлийн уртын дуучин бэлтгэх өдрийн ангийн таван жилийн сургалттай бакалаврын хөтөлбөрийг 2003 оноос эхлүүлж, 2017 оноос дөрвөн жилийн сургалттайгаар 2023 оны байдлаар 57 мэргэжлийн уртын дуучин бэлтгэн гаргасан байна.

Харин хувийн их дээд сургуулиудаас Сити дээд сургууль 2008 оноос анхны төгсөлтөө хийж, 2023 оны байдлаар 50 мэргэжлийн уртын дуучин бэлтгэсэн байна.

Мэргэжлийн уртын дуучны тоог төгссөн он, төгсгөсөн сургууль, хөтөлбөрийн үешлэлээр харуулав (Зураг 1).


Зургаас харвал СУИС-аас дээд мэргэжилтэй уртын дуучин төрөн гарах үйл явц 1994 оноос хойш тасарсангүй, 2000 оноос хойш тогтмол дээшилсээр, 2013 онд хамгийн олон мэргэжлийн уртын дуучин төгссөн гарчээ. Түүнээс хойш бага зэрэг буурсан боловч жил бүр дунджаар 10-аас доошгүй уртын дуучид төрөн гарсаар байна. Эдүгээ СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн уртын дууны багшаар МУАЖ А.Нэргүй, доктор (Ph.D), дэд профессор, МУГЖ Ц.Чулуунцэцэг, С.Цогтсайхан, Монгол улсын консерваторын уртын дууны багшаар МУАЖ Д.Түвшинжаргал, Ц.Насанбат, Б.Батмэнд нар ажиллаж байна. Тэдний багш нь Ц.Дэлгэр (1956-2020), түүний багш нь Н.Норовбанзад (1931-2002), түүний багш нь Ж.Дорждагва (1904-1991), түүний багш нь М.Дугаржав (1893-1946) билээ. Ийнхүү

МОНГОЛЫН УРТЫН ДУУНЫ АЛТАН ХЭЛХЭЭ ҮЛ ТАСРАН УЛАМЖИЛСААР БАЙНА (Дашцэрмаа, 2022).

Эндээс бид Монгол улсад уртын дууг танхимаар зааж ирсэн түүхэн цаг үеийг дараах дөрвөн үечлэлээр хуваан авч үзэж болох юм. Үүнд:

- Уртын дууг танхимаар заахын угтал үе (1930-1968 он). Энэ үед уртын дууг БНМАУ-ын урлагийн тайзан дээр дуулж эхэлсэн. Гэвч их хэлмэгдлийн үеэр уртын дууны хөгжил тасалдаж, маргагдахад хүрсэн. Харин 1968 онд уртын дуучдын улсын уралдааныг зохион байгуулснаар уртын дуу эргэн сэргэх үүд хаалга нээгдсэн байна.
- Уртын дууг танхимаар зааж эхэлсэн үе (1969-1990 он). Энэ үед уртын дууг Ж.Дорждагва багштай зургаан сарын курс (1969 онд), Н.Норовбанзад захиралтай гурван сарын түр сургууль (1974)-аар цөөн биш хүнд (30 гаруй) заан сургажээ. Мөн 1970 оны үед анхны мэргэжлийн уртын дуучин (Н.Норовбанзад багшийн шавь Цэвэгсүрэн) төрөн гарч, 1977 онд УБДС-ийн дуулаачийн ангид уртын дууны мэргэжлийн элсэлт авч, 1982 онд дээд боловсролтой анхны гурван уртын дуучин төгсжээ. Гэвч уртын дууны сургалт жигд биш, үе үе тасалдсан байдалтай байв.
- Уртын дууны танхимын сургалт тасралтгүй явж ирсэн үе (1991-2009 он). Энэ үед харин уртын дууны сургалт тасалдсангүй, жил тутамд 1-10 хүн дээд мэргэжилтэй уртын дуучин болж төгсөн гарсаар иржээ.
- Уртын дууны танхимын сургалт дээшилж ирсэн үе (2009-2021 он). Энэ үед уртын дуучид төгсөгчдийн тоо нэмэгдсээр, жил тутамд 10-аас дээш уртын дуучид төрөн гарсаар байна.

Монгол улсад 1991 оноос өдгөөг хүртэл дунджаар 360 гаран мэргэжлийн уртын дуучин бэлтгэгдэн гарч, төрийн болон хувийн мэргэжлийн театр чуулга, бие даасан чөлөөт уран бүтээлчээр ажиллаж, биет бус өв соёлыг хадгалах хамгаалах үйлсэд хүчин зүтгэж байна.



Зураг 1. Монгол улсад мэргэжлийн уртын дуучин бэлтгэсэн үе шат (1970-2023 он), сургуулиар

Мэргэжлийн уртын дуучдыг бэлтгэн гаргаж буй гурван их дээд сургуулийн төгсөгчдийн өрсөлдөх чадвар, мэргэжлийн байгууллагын орон тооны гүйцэтгэл, хэрэгцээ, зах зээлийн хэрэгцээ зэрэг олон хүчин зүйлийг судалж, цаашдын чиг хандлагыг гаргах шаардлагатай байгааг энэхүү судалгааныхаа явцад харсан билээ.

Иймээс бид 2023 онд мэргэжлийн уртын дуучдаас судалгаа авч санамсаргүй түүврийн аргаар 198 нийт 2 бүлэг, 10 асуулт бүхий асуумжийг боловсруулж, мэдээлэл цуглуулалтыг google form online программыг ашиглан ерөнхий мэдээллийн баазыг үүсгэлээ. Мэдээллийг боловсруулалтыг SPSS 24 software ашиглав. Үр дүнг дундаж утга, стандарт хазайлт, хувиар илэрхийлэн тайлагнав.

Судалгаанд хамрагдсан мэргэжлийн уртын дуучдын дундаж нас 36 ± 9.9 , уртын дуугаар дунжаар 7 ± 7.8 жил хичээллэсэн байна. Судалгаанд хамрагдагсад 100 хувь дээд боловсролын сургалтаар уртын дуучин мэргэжлийг эзэмшсэн байна. *Хүснэгт 1*-д судалгаанд хамрагдагсдын ерөнхий мэдээллийг харуулав. Хүснэгтээс харахад, судалгаанд хамрагдагсдын 90 орчим хувь мэргэжлээрээ ажиллаж байгаа ч мэргэжлийн байгууллагад ажиллагсад 49.5 хувийг нь эзэлж байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан мэргэжлийн уртын дуучдын ерөнхий мэдээлэл

№	Хүн ам зүйн үзүүлэлт	Хувь (тоо)
1. Хүйс		
	Эрэгтэй	26.7 (53)
	Эмэгтэй	73.3 (145)
2. Боловсролын зэрэг		
	Бакалавр	74.7 (148)
	Доктор	1.5 (3)
	Магистр	23.7 (47)
3. Мэргэжил		
	Уртын дуучин	74.2 (147)
	Хавсарсан давхар мэргэжил	25.8 (51)
4. Ажил эрхлэлтийн байдал		
	Мэргэжлийн чуулга театр, сургуульд ажилладаг	49.5 (96)
	Хувь уран бүтээлчээр ажилладаг	40.4 (80)
	Өөр салбарт ажилладаг	11 (22)
	Нийт	100 (198)

Дээрх судалгааны үр дүнгээс ажиглахад, цаашид их дээд сургуулиудыг мэргэжлийн уртын дуучин мэргэжлээр төгсөгчдийн суурь мэдээллийн сантай болж, ажил эрхлэлт, төгсөлтийн дараах сургалтын хамрагдалт, уран бүтээлчийн урын сангийн баяжилтыг, мэргэжлийн байгууллагын эрэлт, сургуулиудын мэргэжлийн боловсон хүчний бэлтгэх зэрэгт нарийвчилсан судалгаа хийх хэрэгцээ байна. Мөн түүнчлэн нутаг нутгийн аялгууны онцлогтой уртын дууны судалгааг өргөтгөх, өвлөн уламжлагч нарын урын санг бүртгэлжүүлэх, мэргэжлийн сургуулийн сургалт, судалгааны эргэлтэд оруулах зэрэг олон талт нарийвчилсан судалгааг гүйцэтгэх шаардлагатай байна.

Түүнчлэн мэргэжлийн уртын дуучин, мэргэжлийн уран бүтээлчийн маш үнэ цэнтэй нарийн ойлголтыг ЮНЕСКО-оос 1980 онд гаргасан тодорхойлолт ухагдахуунд ойртуулан сургалтын хөтөлбөр болон мэргэжлийн байгууллагуудад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг бодлогоор дэмжихэд судалгааны ажлыг нарийвчлах нь зүйтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

1. Монгол улсад мэргэжлийн уртын дуучин бэлтгэх сургалт нь гурван сарын сургалтаас эхлэн 4-5 жилийн сургалтын хөтөлбөртэй нарийн мэргэжлийн уран бүтээлч хүртэл үндэсний хэмжээнд Улсын багшийн дээд сургуулийн урлагийн тэнхимээс гараагаа эхлэн, Соёл урлагийн их сургууль, Монгол улсын консерватор, Сити их сургуулиар дамжуулан нийт 360 гаран мэргэжлийн уртын дуучдыг 1970 оноос бэлтгэсэн байна. Тиймээс мэргэжлийн уртын дууны сургалтыг бэлтгэж ирсэн үе шатыг 45 хоног, зургаан сарын курсын сургалтын үеийг оруулахгүйгээр ангилах боломжгүй юм. Энэ үед суралцсан хүмүүс нь одоогийн Монгол улсын уртын дуучдын залгамж халааг бэлтгэн, орон нутгийн театр чуулгын уран бүтээлчид байгаагаараа онцлог юм.
2. Мэргэжлийн уртын дуучдын 50 орчим хувь үндэсний болон орон нутгийн мэргэжлийн театр, чуулгад ажиллаж байгаа бол үлдсэн хувь нь чөлөөт уран бүтээлч, өөр салбарт ажиллаж байгаа нь энэхүү судалгааг илүү нарийвчлан өргөн хүрээнд судалж, мэргэжлээрээ ажиллахад учирч буй шалтгааныг тодорхойлох үндэслэл болж байна гэж дүгнэж байна.
3. Монгол улсын хөдөө орон нутагт уртын дуугаа өвлөн уламжлагч ЕБС-ийн багш, ажилтан, сум, аймгийн соёлын төвийн дуучин, жирийн малчин ард одоо ч гэрийн сургалт, танхимын сургалт хосолсон ардынхаа уламжлалт аргаар хүүхэд багачууддаа сайн дураараа уртын дуугаа зааж сургах уламжлал байсаар байна.
4. Цаашид мэргэжлийн уртын дуучин бэлтгэн гаргаж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг харьцуулан судалж сургалтын чанар, бэлтгэгдэн гарч буй мэргэжилтэн, багшлах боловсон хүчин, судлаачдыг бэлтгэх зэрэг олон талт суурь судалгааны баазтай болох нь зүйтэй байна.

Ашигласан материалын жагсаалт

Ном

1. Дорждагва, Мягмарсүрэн. 2018. *Халхчуудын уртын дуу, зан үйл*. Улаанбаатар, Монгол Улс.
2. Бадраа, Жамц. 1998. *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар, Монгол Улс.
3. Норовбанзад, Намжил. 2000. *Талын морьтны дуу*. Улаанбаатар, Монгол Улс.
4. Эрхэмтөгс, Жүгдэрнамжил. 2019. *Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол практикийн асуудал*. Улаанбаатар, Монгол Улс.

Ярилцлага

1. Цэрэнпилийн Дашцэрмаатай хийсэн ярилцлага. 2022. Улаанбаатар хот. 2022.05.16. 00:12:01.
2. Адилбишийн Нэргүйтэй хийсэн ярилцлага. 2023. Улаанбаатар хот. 2023.02.15. 00:15:01.
3. Маналын Төмөрбаттай хийсэн ярилцлага. 2023. Улаанбаатар хот. 2023.02.12. 00:10:01. Архивын эх сурвалж СУИС-ийн архив. 2022. Уртын дуу төгсөгчдийн материал.